



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах  
журамд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, "Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/227 дугаар тушаал, байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/148 дугаар тушаалаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын Даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах журам"-ын 3.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчилсүгэй:

"3.1. Зөвлөл дараахь бүрэлдэхүүнтэй байна.

|                       |                                                              |
|-----------------------|--------------------------------------------------------------|
| Зөвлөлийн дарга:      | Дарга                                                        |
| Нарийн бичгийн дарга: | Нууц хариуцсан мэргэжилтэн                                   |
| Гишүүд:               | Дэд дарга                                                    |
|                       | Захиргаа, удирдлагын газрын дарга                            |
|                       | Виз, зөвшөөрөл, харьяатын газрын дарга                       |
|                       | Хяналт, шалгалтын газрын дарга                               |
|                       | Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга                    |
|                       | Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга" |

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Д.Түвшинтөр/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

000000203